

“Зүүн хойд азийн асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын бага хурал

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Зүүн хойд Азийн асуудлаархи Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г өрнүүлэх санаачлагыг 2013 оны дөрөвдүгээр сард Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын ҮШ хурлын үеэр дэвшүүлсэн. Энэхүү санаачлага ажил хэрэг болж эхэлсний анхных нь өнгөрсөн онд Азийн эмэгтэй парламентчидын бага хурлыг зохион байгуулсан бол удаах нь энэ оны тавдугаар сарын 17-18-ны өдрүүдэд нийслэл хотноо болсон Олон улсын бага хурал юм. Олон улсын бага хурлын дөрвөн салбар хуралдаанд Монгол, БНАСАУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон, АНУ, Голланд, ХБНГУ, ИБУИНВУ-ын судалгааны байгууллагын өндөр хэмжээний экспертүүд, эрдэмтэн судлаачид Зүүн хойд Азийн аюулгүй байдлын эрсдэл, эдийн засаг, дэд бүтцийн хамтын ажиллагаа болон бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх асуудлаар хэлэлцэж, санал бодлоо солилцлоо. Хуралд оролцсон төлөөлөгчдийн бүрэлдэхүүн, хэлэлцүүлсэн илтгэлийг хураангуйлан авч үзье.

“Зүүн хойд Азийн аюулгүй байдлын өнөөгийн тулгамдсан асуудал” хэмээх эхний салбар хуралдаанд ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Монгол судлалын секторын эрхлэгч, нэрт монгол судлаач, Sc.D, профессор В.В. Грайворонский “Орос- Монгол- Хятадын стратегийн түншлэл ба ЗХА-ийн аюулгүй байдал”, БНСУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Рянь Кань

ОЛОН УЛС СУДЛАЛ

“ЗХА-д итгэлцлийг бэхжүүлэх бүтцийг авч үзэх нь”, БНХАУ-ын Олон улс судлалын хүрээлэнгийн Ерөнхийлөгч, доктор Ку Шинь “ЗХА-ийн аюулгүй байдлын өнөөгийн тулгамдсан асуудлууд”, АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийн Зүүн Ази судлалын төвийн судлаач, нэрт монголч, доктор, хатагтай Алиса Кампи “ЗХА-ийн аюулгүй байдал: Сорилтыг багасгаж, боломжийг нэмэгдүүлэх шинэ хандлага” гэсэн илтгэлүүд тавьж хэлэлцүүлээ.

“ЗХА-д Аюулгүй байдлын механизм байхгүй байгаагийн шалтгаан нөхцөл” сэдвийн хүрээнд болсон удаах салбар хуралдаанд Стратеги судлалын хүрээлэнгийн захирал, доктор Д.Ганбат “ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ”, БНСУ-ын Үндэсний нэгдлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ж.Пак “ЗХА-ын аюулгүй байдлын олон талт механизмын талаархи Өмнөд Солонгосын санаачлага”, Японы Олон улс судлалын хүрээлэнгийн ахлах судлаач, доктор Сэичиро Такаги “Япон, Хятадын хоорондох арлын маргаан, стратегийн хүчин зүйлс”, БНХАУ-ын Дэлхийн бодлого судлал, Хятадын өнөөгийн олон улсын харилцааны хүрээлэнгийн дэд захирал, доктор, хатагтай Сан Ру “ЗХА-ийн өнөөгийн байдал: боломж, сорилт” илтгэлүүд тавьж хэлэлцүүлээ.

“Бүс нутагт итгэлцэл хамтын ажиллагааг бэхжүүлэхэд эдийн засаг, байгалийн болон бусад хүчин зүйлсийн үүрэг роль” гутгаар салбар хуралдаанд ОХУ-ын Буриадын улсын их сургуулийн дэд профессор В.А. Родинов “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал ЗХА-ийн хөгжил цэцэглэлтэнд хамаарах нь”, БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн Их гүрэн судлалын соторын эрхлэгч, дэд профессор Зонь Пэйтень “Азийн аюулгүй байдлын архитектурыг бэхжүүлэхэд Хятадын шинэ бодлого”, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор Ц.Баатар “ЗХА-д /3+1/ хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж”, Японы Зүүн хойд Азийн эдийн засгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Хирофүми Араи “ЗХА-ийн хил орчмын дэд бүтцийг хөгжүүлэх нь”, АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийн Зүүн Ази судлалын төвийн захирал, доктор Кент Калдер “Евроазид гарч буй аюулын хандлага”, БНСУ-ын

Ёнсей их сургуулийн дэд профессор Ким Жун Мин “Монголд хийн хоолой татах төсөл” гэсэн сонирхолтой илтгэлүүд тавьж хэлэлцүүлээ.

“ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааг ойртуулах, итгэлцлийг урагшлуулах нь” дөтгөөр салбар хуралдаанд БНХАУ-ын Олон улсын стратеги судлалын хүрээлэнгийн дэд дарга, доктор Хуань Байфу “ЗХА-д энх тайван, тогтвортой байдлыг хангаж, хамтын үр дүнд хүрэхэд харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь”, АНУ-ын Калифорны их сургуулийн Зүүн Ази судлалын профессор Т.Ж. Пемпел “ЗХА-д газрын мина-аас зайлсхийх нь”, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, монгол судлаач, доктор, хатагтай Е.В. Бойкова “ЗХА-ийн аюулгүй байдал: боломжит механизм”, БНСУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний төлөвлөлт, захиргааны газрын Ерөнхий захирал, доктор Ки Дук Ли “ЗХА-ын аюулгүй байдлын механизм бий болгоход ашиглахуйц боломжит загварчлалууд”, Японы Токай их сургуулийн профессор Хироиүки Фүжимаки “Төв Азийн бүс нутагт уламжлалт бус аюулгүй байдлын роль”, Бүрэн эрхт элчин сайд, доктор Ж. Энхсайхан “ЗХА-Цөмийн зэвсэггүй бүс нутаг үүсгэн байгуулах нь” илтгэлүүд тавьж хэлэлцүүлээ.

Илтгэлүүдтэй холбогдуулан хэлэлцүүлэг өрнүүлж, эрдэмтэн судлаачид ур ухаанаа уралдуулж, зарим асуудлаар нэлээд хурц мэтгэлцсэн нь, харилцан ойлголцолд хүрэх, санал бодлоо илэн далангүй чөлөөтэй солилцоход зохих үр дүнгээ өглөө.

Олон улсын эрдэмтэн судлаачид ЗХА-ийн бүс нутагт тулгамдаж буй аюулгүй байдлын асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхэд энэ бүс нутгийн бүх улс оронтой найрсаг харилцаатай Монгол улс хувь нэмрээ оруулах бүрэн боломжтойг онцолж, ийм яриа хэлэлцээний механизм бий болгох эхний алхмыг Монгол Улс тавьж байгаад ихээхэн ач холбогдол өгч байлаа.

Ц.Баатар